

**ГАРЧИГ**

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим.....	4
1.2. Бүтээгдэхүүн тээвэрлэлт.....	5
1.3. Үйлдвэрийн усан хангамж .....	5
2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	6
3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	7
3.1.Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр.....	7
3.2.Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр.....	9
3.3 Төслийн гол сөрөг нөлөөлөл .....	10
4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ ...	10
4.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	11
4.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
4.3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	16
4.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	16
4.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	17
4.6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	18
4.7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	19
4.8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	19
4.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	21
4.10. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	22
4.11. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ .....	22

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим .....	4
Хүснэгт 2. Химийн бодисын хэрэглээ .....	4
Хүснэгт 3. Бүтээгдэхүүн гаргалт .....	4
Хүснэгт 4. Автосамосвалын /HOWO/ техникийн тодорхойлолт .....	5
Хүснэгт 5. Усны зарцуулалтын нэгдсэн товчоон .....	5
Хүснэгт 6. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр .....	7
Хүснэгт 7. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр .....	9
Хүснэгт 8. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа .....	10
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төсөв .....	11
Хүснэгт 10. ....	15
Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв .....	16
Хүснэгт 12. ....	17
Хүснэгт 13. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсөв .....	17
Хүснэгт 14. Осол эрсдэлийн менежментийн төсөв .....	18
Хүснэгт 15. Хог, хаягдлын менежментийн төсөв .....	19
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний төсөв .....	20
Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төсөв .....	21
Хүснэгт 18. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төсөв .....	22
Хүснэгт 19. Нийт төсвийн задаргаа .....	22

### 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Хөх Бишрэлт” ХХК-ийн баяжуулах үйлдвэр нь төслийн бүрэн хүчин чадлаар ажиллах тохиолдолд жилд 150 мян.тн хүдэр боловсруулж, 22.5 мян.тн 97 %-н (CaF<sub>2</sub>) агуулагатай жоншны баяжмал гарган авах хүчин чадалтай. 2023 онд **39.5** мян.тн хүдэр боловсруулахаар төлөвлөж байна. Боловсруулалтанд оруулах жоншны хүдрээ Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших Дэлгэр-3 хайлуур жоншны болон Хэнтий аймгийн Галшар сумын нутагт орших Буянтын жоншны уурхайгаас авахаар холбогдох гэрээг байгуулсан.



Зураг-1. Цагаан-дэлийн жонш баяжуулах үйлдвэрийн байршил



Зураг-2. Хүдэр тээвэрлэх маршрутын схем зураг

**1.1. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим**

“Хөх Бишрэлт” ХХК-ийн баяжуулах үйлдвэр нь 2023 онд 210 хоног, 3 ээлжээр, хоногт бодит цагаар 21.6 цаг ажиллана.

*Хүснэгт 1. Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим*

Хүдэр бутлах цехийн ажиллах горим	Тоон утга
Жилийн хуанлийн өдрийн тоо	365
Жилийн хуанлийн сар	12
Жилийн хуанлийн цаг	8,760
Өдрийн хуанлийн цаг	24
Цех ашиглалт, %	90
Өдөрт ажиллах бодит цаг	21.6
Жилд ажиллах бодит хоног	210
Цагийн хүчин чадал, т/цаг	8.7
Хоногийн хүчин чадал, тн/хон	188.1
Жилийн хүчин чадал, тн/жил	39,500

Флотацид кальцийн сод, шингэн шил, хүхэр хүчлийн хөнгөн цагаан, тосны хүчил, шохой зэрэг урвалжууд хэрэглэгдэнэ.

*Хүснэгт 2. Химийн бодисын хэрэглээ*

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Норм	Жилийн хэрэгцээ /тн/	2023 он
1	Нийт хүдэр	мян. тн			35.5
2	Гаргах баяжмал	мян.тн			14.281
3	Ган бөмбөлөг	кг/тн	1.5	15	53.25
4	Фильтрын шүүлтүүр	м <sup>2</sup> /тн	0.02	0.2	0.2
5	ЖКТМ	кг/тн	0.4	4	14.2
6	Сод (Na <sub>2</sub> CO <sub>3</sub> )	кг/тн	0.3	3	10.65
7	Шингэн шил( Na <sub>2</sub> SiO <sub>2</sub> )	кг/тн	2.4	24	85.2
8	Полиакриалмид	кг/тн	0.02	0.2	0.2

*Хүснэгт 3. Бүтээгдэхүүн гаргалт*

Бүтээгдэхүүний нэр	Бүтээгдэхүүний гарц, %	CaF <sub>2</sub> -н агуулга, %	CaF <sub>2</sub> -н металл авалт, %
Анхдагч хүдэр	100	43.85	100
Баяжмал	40.2	97	88.99
Хаягдал	59.8	8.08	11.01

## 1.2. Бүтээгдэхүүн тээвэрлэлт

Гарган авах ФФ97 маркийн баяжмалыг үйлдвэрээс баруун зүгт 50 км-т орших Бор-Өндөрийн төмөр замаар тээвэрлэж БНХАУ-д экспортлох юм. Баяжмалыг HOWO маркийн автосамосвалаар 2 тн-н багтаамжтай уутанд савлаж тээвэрлэнэ.

*Хүснэгт 4. Автосамосвалын /HOWO/ техникийн тодорхойлолт*

Д/д	Үзүүлэлтүүд	Нэгж	HOWO
1	Загвар	-	6x4 truck
2	Даац	тн	31-40
3	Овор хэмэжээ /урт, өргөн, өндөр/	мм	8214x2496x3386
4	Жин	тн	9
4	Хөдөлгүүрийн чадал	HP	371
5	Хамгийн их хурд	км/цаг	75

## 1.3. Үйлдвэрийн усан хангамж

Баяжуулах цехийн жилд хэрэглэгдэх усны хэрэгцээг тооцвол:

1тн хүдэр баяжуулахад зарцуулагдах усны хэмжээ  $2.5 \text{ м}^3/\text{тн}$  болж байна.

$63,750 \text{ м}^3: 25,500 = 2.5 \text{ м}^3/\text{тн}$ . Үүний 70 % буюу  $44,625 \text{ м}^3$  нь эргэлтийн усаар, нийт усны 30 % буюу  $19,125 \text{ м}^3$  нь цэвэр усаар тус тус хангагдах болно. Цагт зарцуулах цэвэр усны хэмжээ нь  $2.17 \text{ м}^3/\text{цаг}$  буюу  $0.6 \text{ л/с}$  ундрагатай худаг байна. Үйлдвэрийн 2 худгийн ундрага нь  $5.5 \text{ л/с}$  ундрагатай тул баяжуулах үйлдвэрийн цэвэр усны хэрэглээг бүрэн хангана.

**А) Ахуйн болон ундны хэрэглээний усан хангамж:** Ахуйн хэрэглээний усыг өөрийн өрөмдсөн худгаас хангах ба тус баяжуулах үйлдвэр нь 110 ажиллагсадтай, хоногт хэрэглэх усны хэмжээ нь 8,100 л, жилд 1,296,000 л буюу  $1,296 \text{ м}^3$ , цайны газрын усны хэрэглээ нь хоногт 5,184 л ус, жилд 829,440 л буюу  $829.44 \text{ м}^3$  ус хэрэглэх ба нийтдээ  $1,296+829.44 = 2,125.44 \text{ м}^3$  ус хэрэглэнэ.

**Б) Технологийн усан хангамж:** Технологийн усан хангамжид үйлдвэрлэлд хэрэгцээтэй нэмэлт усан хангамж орох бөгөөд нийт  $44,625 \text{ м}^3$  усны 30 %-ийг буюу  $19,125 \text{ м}^3$  цэвэр усаар хангана.

**В) Эргэлтийн усан хангамж:** Эргэлтийн усан хангамжид хаягдлын усан сангаас буцаж ирэх ус орох бөгөөд нийт  $63,750 \text{ м}^3$  усны 70 % буюу  $44,625 \text{ м}^3$  ус эргэлтийн усаар нөхөгдөнө.

**Г) Бусад усан хангамж:** Бусад усан хангамжид жилд 2.5 га талбайг /тарьсан зүлэг, мод болон шимт хөрсийг услах, мөн дулааны улиралд автозамын тоосжилтоос хамгаалах зорилгоор/ услахад  $2500 \text{ м}^2 \cdot 4 \text{ л/м}^2 \cdot 75 \text{ хоног} = 750 \text{ м}^3$  ус ашиглагдана.

*Хүснэгт 5. Усны зарцуулалтын нэгдсэн товчоон*

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Жилд зарцуулах усны хэмжээ
Технологийн эргэлтийн усны хэрэгцээ/70%/	м <sup>3</sup>	17,500
Нийт технологийн ус нэмж сэлбэх хэрэгцээ /30%/	м <sup>3</sup>	7,500
Ахуйн болон ундны усны хэрэгцээ	м <sup>3</sup>	2,125.46
Бусад усны хэрэгцээ	м <sup>3</sup>	750
<b>Нийт усны хэрэгцээ</b>	<b>м<sup>3</sup></b>	<b>27,875.46</b>

## 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Тус талбай нь гадаргуугийн хувьд жижиг толгодлог болон нам уулс зонхилсон, далайн түвшнөөс дээш дунджаар 1240 м-т өргөгдсөн, харьцангуй өндөр нь 1215 м ба өргөгдсөн уул толгодтой. Талбайн хэмжээнд гадаргуугийн усан сүлжээ муу хөгжсөн ба байнгын урсгал ус байхгүй. Бороо элбэг ороход хуурай сайрууд болон шанд тойрмууд усаар дүүрч түр зуурын урсгал ус бий болдог. Хур тунадаснаас тогтсон нуурын ус нь давс хужиртай. Ундны усанд тохиромж муутай. Уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Өвлийн улирал нь хүйтэвтэр байх ба дундаж хэм нь -20°C, зундаа хамгийн их халдаг ба дундаж температур +27°C байдаг. Өвөлдөө 10-15 см зарим жилд 40-50 см хүртэл цас ордог. Агаарын чийгшилт багатай зонхилох салхи нь баруун, баруун хойд зүгээс салхилдаг. Хавартаа хүчтэй салхитай 30 м/сек хүртэл ширүүсч шороон шуурга шуурдаг байна. Жилд орох хур тунадасны хэмжээ 400 мм-ээс хэтэрдэггүй. Газрын гадарга нь улирлын аль ч цагт авто машинаар зорчиход саадгүй.

Цахилгаан эрчим хүчний зүүн бүсийн цахилгаан түгээх төвөөс Бор-Өндөрийн УБҮ уруу татсан 110 кВ- ийн шугам, түүнээс Бор-Өндөр-Иххэтийн хооронд татсан 35 кВ-ийн өндөр хүчдэлийн шугам дайран өнгөрдөг бөгөөд энэ нь эдийн засаг, дэд бүтцийн маш таатай орчинг бүрдүүлдэг. Баяжуулах үйлдвэр жилд 300 хоног 3 ээлжээр 8 цагаар тасралтгүй бүрэн чадлаараа ажиллавал жилд 150 мян.тонн 19.08 % CaF<sub>2</sub> агуулгатай хүдрийг баяжуулж, 97%-ийн агуулгатай 22.5 мян. жоншны баяжмалыг гаргаж зах зээлд борлуулах юм. Жоншны баяжмалыг экспортод гаргаснаар Монгол улсын экспортын орлогыг нэмэгдүүлэх, сум орон нутгийн хөгжил, цаашлаад улсын төсөвт хувь нэмэр оруулах юм. Мөн орон нутгийн нийгэм-эдийн засгийн таатай нөлөөг үзүүлж байна.

1. Орон нутгийн 80 гаруй иргэнийг ажлын байраар хангасан.
2. Ажиллагсдын цалинг бүс нутгийн дундаж жишгээс багагүй тогтоосон. /дундаж цалин 950000 төгрөг/
3. Үйлдвэрийн машин механизм, тоног төхөөрөмжид шаардагдах шатах тослох материалыг сумын шатахуун түгээгүүрээс авдаг.

4. Зарим шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал, түүхий эдийг орон нутгаас худалдан авна.

### 3. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### 3.1. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Хүснэгт 6. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа		Чиглэл		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцах	Буцалтгүй	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Гадаргын урсацын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x				x	x				x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x		x	x				x
<b>2. Байгалийн нөөц ашиглалт</b>										
Газрын гадаргын нөөц баялаг	x				x	x			x	
Бэлчээрийн байдал	x				x		x			x
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x		x	
Эрчим хүчний нөөц										
<b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>										
Газрын доорх усны чанар, хэмжээ		x		x			x			x
Гадаргын усны чанар хэмжээ										
Агаарын бохирдол	x				x	x			x	
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x	x		
Хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх										
Дуу чимээ, шуугианы нөлөө	x				x	x				x
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор</b>										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x			x
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x			x
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x				x		x		x	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x	x				x
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх	x				x		x		x	



Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x			x		x			x
<b>6. Эдийн засагт үзүүлэх нөлөө</b>										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x		x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x		x	
Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x		x	
<b>7. Бусад нөлөөлөл</b>										
Ажиллагсадын эрүүл мэндэд нөлөөлөх	X				x		x		x	
Шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	X				x		x		x	
Нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах		x		x			x			x
Ахуйн хаягдал, хогийн ариутгал, зайлуулалт муугаас эвгүй үнэр гарч, шавьж үржих	X			x						x
Дүн, 34	21	4	1	3	23	7	19	2	13	11

Эдгээр болзошгүй нөлөөллийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

**Шууд нөлөөлөл:** Болзошгүй нөлөөллийн 21 (62 %) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад хөрс, ургамал, амьтан, газрын гадарга, бэлчээр, байгалийн дүр төрхөд, орчны бохирдол зэрэгт шууд сөргөөр нөлөөлөх муу талтай байна. Харин орон нутгийн нийгэм-эдийн засагт шууд эерэгээр нөлөөлөхөөр байна.

**Шууд бус нөлөөлөл:** Нийт нөлөөллийн 4 (12 %) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Гүний усны чанар, хэмжээ хүн амын эрүүл мэндэд шууд бус сөргөөр, үйлдвэр, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөхөөр байна.

**Нөлөөллийн үргэлжлэх хугацаа:** Үйлдвэрийн үйл ажиллагаанаас нөлөөлөх эерэг ба сөрөг нөлөөллүүдийн дийлэнх нь урт хугацааны нөлөөлөлд (68 %) хамаарагдаж байна. Иймээс сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу байнга тасралтгүй хийж байх шаардлагатай.

**Нөлөөллийн чиглэл:** Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн 19 (56 %) нь буцалтгүй буюу тухайн өөрчлөгдсөн зүйлс эргэн хэвэндээ орохгүй чиглэлтэй байна. Байгаль орчинд сөргөөр, буцалтгүй байдлаар нөлөөлөх тохиолдолд түүнийг нөхөн сэргээхдээ аль болох анхны төрхөд нь дөхүүлэх эсвэл дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авах нь зүйтэй. Харин нийгэм-эдийн засагт эерэг, буцалтгүй нөлөөллийн эрчмийг дээшлүүлэх тал дээр төсөл хэрэгжүүлэгч анхаарвал зохино.

**Нөлөөллийн эрчим:** Энэ төслийн хүчтэй сөрөг нөлөөлөлд ажиллагсдын эрүүл мэнд өртөж болзошгүй. Гэвч үүнийг бууруулах үүднээс ХХАА-ны журмыг сайтар



баримтлана. Хөрсний эвдрэл бохирдолд хүчтэй, ургамал, газрын гадарга, эрдэс түүхий эдийн нөөц, орчны бохирдол зэрэгт дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл, харин ажлын байр, орон нутагт төвлөрүүлэх татвар нэмэгдэх, ажилчдын суурин байгуулагдах нь орон нутгийн нийгэм-эдийн засагт эерэг (дунд зэргийн) нөлөөлөл үзүүлэхээр байна. Нийт 26 нөлөөллөөс 2 нь хүчтэй, 13 нь дунд зэрэг, 11 нь сул нөлөөлөл бөгөөд 16 нь сөрөг, 10 нь эерэг нөлөөлөл байна.

### 3.2.Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр

Хүснэгт 7. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн шинж чанар
Агаар орчин			
1	Тоосжилт	Үйлдвэрийн үйл ажиллагаа Хүдрийн овоолго Тээвэрлэлт	Улирлын чанартай Хамрах хүрээ хязгаарлагдмал Амархан сарнина
2	Хийн хаягдал, утаа	Автомашин Үйлдвэрийн автотехникүүд	Агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэр Хадгалагдах ба тархах хүрээ хязгаарлагдмал Амархан сарнина
Усан орчин			
3	Хатуу болон шингэн хог хаягдал	Хог хаягдал болон шатах тослох материалын хаягдал Бохир ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал	Шатах тослох материал асгарснаас хөрс, хөрсний ус бохирдох Хур борооны усаар аливаа хог хаягдал, асгаралт угаагдаж хөрсний ус бохирдуулах
4	Үйлдвэрийн үйл ажиллагаа	Үйлдвэрийн баяжуулалтын үйл ажиллагаа	Үйлдвэрийн явцад хөрсний ус илэрч, карьер усанд автах
Хөрсөн бүрхэвч, геологийн тогтоц			
5	Хөрсний элэгдэл, эвдрэл	Хөрс хуулалт Автотехникийн үйл ажиллагаа	Хамрах хүрээ хязгаарлагдмал Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөх
6	Бохирдол	Ахуйн хог хаягдал ил задгай асгах	Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана
Ургамлын нөмрөг			
7	Ургамлын талхагдал	Авто зам Ашиглалтын талбай, барилга байгууламжуудын орчин Тоосжилт	Хэмжээ хягаарлагдмал ба ургамалжуулалт хийснээр нөхөн сэргэх Тухайн орчны ургамалан нөмрөгийн төрөл зүйл багасах, хомсдох
8	Ургамлын нөмрөг устах	Нэн ховор, ховор ургамалыг таньж мэдэхгүй харьцах	Төрөл зүйл өөрчлөгдөх Устах
Ан амьтан			
9	Хордолт	Хог хаягдал болон шатах тослох материалын хаягдал	Хөрсөн дэх бичил биетэн, шавж үрэгдэх
10	Дайжих	Дуу чимээ Үйлдвэрийн үйл ажиллагаа	Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих
Нийгэм-эдийн засгийн орчин			
11	Үндсэн хөрөнгө	Татварын орлого Бүтээгдэхүүн үйлчилгээний худалдан авалт, орлого Орон сууц	Төсөвт татвар төлөх Ойролцоох оршин суугч, аж ахуй эрхлэгчдийн орлого нэмэгдэх, амьжиргаа дээшлэх Сумын дэд бүтэц сайжрах, тохилог орон сууц нэмэгдэх

12	Ажлын байр	Ажлын байр шинээр бий болох	Орон нутгийн иргэдээс ажилд авах Тогтмол орлогын эх үүсвэртэй болох
----	------------	-----------------------------	---

### 3.3 Төслийн гол сөрөг нөлөөлөл

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс жонш боловсруулах үед хөрс, агаар, бэлчээр, ургамал зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна.

*Хүснэгт 8. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа*

№	Нөлөөллийн голлох хүчин зүйл	Нөлөөлөлд өртөх орчин	Байршил	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1	Тоосжилтоос бохирдох	Агаар	Бутлах, нунтаглах машины орчим	75 хүн	Дунд зэрэг	Богино
2	Чимээ шуугианы физик бохирдол	Агаар	Үйлдвэрийн байранд	75 хүн	Дунд зэрэг	Богино
3	Хатуу шингэн хог хаягдал	Хөрс	Бохирын шугам, гадаад орчин	Орчны талбай	Бага зэрэг	Урт
4	Хаягдлын сангийн хаягдал	Гүний ус	Баяжуулах	Орчны талбай	Бага зэрэг	Урт
5	Мэргэжлээс шалтгаалах өвчлөл	Хүн	Ажиллагсад	75 хүн	Дунд зэрэг	Урт

## 4. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ

Гол зорилт: Бид 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа 2022 онд “ЕАСС” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Цагаан дэлийн жонш баяжуулах үйлдвэрийн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүргээс гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан **үүрэг даалгавруудыг** биелүүлэхийг гол зорилго болгосон.

Хамрах хүрээ: Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт нэгж талбарын 4409050023 дугаар бүхий 35 м2 талбай хамрагдах бөгөөд баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн хэсгүүдэд хамаарна.

#### 4.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төсөв

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
<b>Агаарын чанар</b>									
1	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, автомашин, техникүүдээс гарах тоосжилт нь агаарын чанарт нөлөөлөх	Замын гадаргын шаардлагатай хэсгүүдэд засах, усалгааг хийх	Төслийн талбай	м3	0.185	750	138.7		Агаарын тухай хууль
2									
3		Үйлдвэрийн орчны авто замын хурдны хязгаарлалтыг заасан тэмдэгжүүлэлтийг нэмэх, сайжруулах	Авто зам	ш	100	4	400.0		Агаарын тухай хууль  Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм
4		Тээврийн хэрэгслийн ашиглалт, техникийн байдалд хяналтын үзлэг, системүүдийн техникийн байдлыг оношлуулах, шаардлагатай бол засвар тохиргоог хийлгэх	Техник, автомашин	ш	80	5	400.0		Бензин хөдөлгүүрт автомашин утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2003

									Дизель хөдөлгүүрт автомашины утааны найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2003
<b>Хөрсний чанар</b>									
5	Шатах тослох материалын асгаралтаас хөрс бохирдох	Шатах тослох материал, химийн бодисын хадгалалтанд хяналт тавих	Материалын агуулах	-	-	-	Үйл ажиллагааны зардал		Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014
6	Олон салаа шороон зам, далангаас хөрсний бүтцэд өөрчлөлт орох	Тээвэрлэлтийн олон салаа зам гарахаас сэргийлж дотоод, гадаад замын 2 талаар хязгаарлах далан тэмдэг тэмдэглэгээ хийх	автозам						Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
<b>Гадаргын ба газрын доорхи усны нөөц</b>									

7	Гадаргын ба газрын доорхи усны нөөц багасах	Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, тэмдэгжүүлэх, хамгаалах, эрүүл ахуйн бүсэд мөрдөх дэглэмийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Гүний худаг	ш	300	1	300.0		<ul style="list-style-type: none"> <li>Усны тухай хууль</li> <li><b>“Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”</b> /БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт/</li> </ul>
8		Жонш боловсруулалтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах.	Гүний худаг				Үйл ажиллагааны зардал		<ul style="list-style-type: none"> <li>Байгаль орчныг хамгаалах тухай хууль</li> <li>Усны тухай хууль</li> <li>ЗГ-ын 2013.09.21-ний 326-р тогтоолын 1-р хавсралт “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ”</li> <li>“Зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны норм” /БОНХАЖ-ын сайдын 2015.07.30-ны А/301 тушаалын хавсралт-13/</li> </ul>
<b>Ургамлан нөмрөг</b>									
	Ургамал								

9	талхлагд ах ургамлын нөмрөг доройтох	Тэрбум мод хөдөлгөөнд идэвхи санаачилгатай оролцож, мод тарих усалгаажуулах	Нөлөөллийн бүсэд	га	1	2500	2,500.0	5, 10сар	
10		Шимт хөрсний агрохимийн шинжилгээг хийлгэх, хадгалалтыг сайжруулах, салхинд хийсэхээс хамгаалж гадаргын хэсгийг ургамалжуулах	Шимт хөрс	га	-	0.22	432.5		MNS 5916 : 2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
<b>Нийт</b>							<b>5562.7</b>		

## 4.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10.

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Хүдрийн овоолгыг хэлбэржүүлэх	га	1		800.0	Жил бүр	
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний арчилгаа, усалгаа, тордолт	га	1.1		1,000.0	Жил бүр	
	<b>Нийт</b>					<b>1,800.0</b>		



### 4.3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Уул уурхайн олборлолтын улмаас нөхөн сэргээгдээгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх	Дорноговь аймгийн БО-ны газраас өгсөн чиглэлийн дагуу Иххэт сумын “Хөх өндөр” нэртэй газарт хэсэгчилсэн техникийн нөхөн сэргээлт хийх	Сум, орон нутаг	2га	2,000.0	4000.0	III улиралд	<ul style="list-style-type: none"> <li>• БОНБУ-ний тухай хуулийн 3.1.11</li> </ul>
2		Орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд Иххэт сумын 1-р багийн нутаг орших “Хөгцөт” нэртэй булгийн эхийг хашаажуулах		100м2	200.0	4,000.0	II улиралд	<ul style="list-style-type: none"> <li>• БОННУ-ний нэмэлт тодотгол тайлан</li> </ul>
<b>Дүн</b>						<b>8,000.0</b>		

#### 4.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох үйл ажиллагаа явагдахгүй болно.

Хүснэгт 12.

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.								
	<b>Нийт</b>							

#### 4.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.

Хүснэгт 13. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсөв

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед архелогийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй	Энэ тохиолдолд заавал төрийн холбогдох байгууллагуудад мэдэгдэх	Төслийн талбайн хэмжээнд			Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны туршид	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2	Сум орон нутгийн хэмжээнд соёлын биет бус өвийг хамгаалах, биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой зохион байгуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Сум орон нутгийн хэмжээнд			1,500.0		Соёлын өвийг хамгаалах тухай хууль
	<b>Нийт</b>					<b>1,500.0</b>		

### 4.6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн боловсруулалтын үйл ажиллагаанд химийн бодисыг ашигладаг

тул химийн бодисоос үүсэх эрсдэлтэй юм.

Хүснэгт 14. Осол эрсдэлийн менежментийн төсөв

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Химийн бодисын асгаралт, эрсдэл	Химийн бодисыг тухайн бодисын ХАЛМ-д заасны дагуу хадгалах, химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг шаардлагатай газруудад байрлуулах	Баяжуулах үйлдвэр, Лаборатори,	1	-	1,000.0	Жилийн турш	<ul style="list-style-type: none"> <li>Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль</li> <li>Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014</li> </ul>
	Шатах тослох материалын талбайг бетонон гадаргуутай болгох		Химийн бодисын агуулах					
2	Химийн бодисын асгаралт, эрсдэл	Химийн бодисын хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюулгүй ажиллагааны зааварчилгааг шинэчилж боловсруулан, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах, химийн бодис хадгалах агуулахад шинээр дүгнэлт гаргуулах			-	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2.1.2, 2.1.4 дахь заалт
								Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014
3	Химийн бодисын асгаралт, эрсдэл	Шатах тослох материалын болон хаягдлын түр цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх, асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах	Ажилчдын байр, хог хаягдлын түр цэг,	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014
4		Химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх						Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 4.5, 4.1.2 дахь заалт
5	Гал түймэр	Галын аюулаас хамгаалах багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаж байнга сэлбэх	Төслийн талбайн бүх байр	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	Галын аюулгүй байдлын тухай хууль 3-р бүлэг Гамшгаас хамгаалах тухай хууль, 5-р бүлэг
6	Хаягдлын сангийн далан нурах сэтгэх	Хаягдлын сангийн тогтворжилтыг тогтмол хянах	Хаягдлын сан			Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	Гамшгаас хамгаалах тухай хууль 5-р бүлэг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 5-р бүлэг
<b>Дүн</b>						<b>1,000.0</b>		

**4.7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 15. Хог, хаягдлын менежментийн төсөв

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
	1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгаж, хог хаягдал хадгалах түр цэгийг хашаа хамгаалалт хийж, тохижуулах, хяналт тавих	Төслийн талбай	ш	1000.0	1	1000.0	3 сар	Хог хаягдлын тухай хууль	
2		Орон нутагтай хог хаягдал нийлүүлэх гэрээ хийж тухай бүрт хүлээлгэн өгөх		төг/сар				Сар бүр	Хог хаягдлын тухай хууль	
3		Дахин ашиглах хаягдлыг дахивар авах ААНБ-тай гэрээ хийн нийлүүлэх		тн	-	-		Жилийн туршид	Хог хаягдлын тухай хууль	
4		Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг дарж булшлах, хог хаягдлын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Сум,орон нутаг			Жилийн туршид		Байгаль орчныг хамгаалах тухай хууль,		
5	Үйлдвэрийн	Үйлдвэрийн талбайн гадаад дотоод орчны цэвэрлэгээг хийж хог хаягдалгүй цэвэр орчин бүрдүүлж ажиллах	Төслийн талбай				500.0	Сар бүр	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хог хаягдлын тухай хууль	
6		Тоног төхөөрмжийн засвар үйлчилгээний явцад гарсан хог хаягдлыг тусгайлан хадгалах, ангилж ялгах		Жилийн туршид	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль,					
7	Аюултай	Ашиглагдсан шатах тослох материал болон химийн бодисын сав, баглаа боодлыг түр аюулгүй нөхцөлийг бүрдүүлсэн орчинд хадгалах, гэрээлэгч компанид нийлүүлж, акт үйлдэх,		Төслийн талбай				Үйл ажиллагааны зардал	Жилийн туршид	"Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам" ЗГ-ын 2018.05.02-ны 116-р тогтоолын хавсралт-1
8		Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр төрөл бүрээр бүртгэл хөтлөх /хуулийн хугацаа өнгөрсөн тохиолдолд эрх бүхий байгууллагад шилжүүлэх/			Жилийн туршид					
<b>Нийт</b>								<b>1500.0</b>		

### 4.8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний төсөв

	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
<b>1. Агаарын чанар</b>								
1.1	Тоосонцор: PM10, PM2,5	Хүдрийн овоолгын зам, шимт хөрс, хаягдлын сан зүүн талд	Хагас жил тутам	2	35.0	70.0		MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
1.2	Зарим хийнүүд: хүхрийн давхар исэл-SO <sub>2</sub> , азотын давхар исэл-NO <sub>2</sub> , нүүрсхүчлийн хий-CO,	Хүдрийн овоолгын зам, шимт хөрс, хаягдлын сан зүүн талд	Хагас жил тутам	2	35.0	140.0		
	Дүн					235.0		
<b>2. Хөрсний чанар</b>								
2.1	Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүд	Шимт хөрс,	Жилд нэг удаа	1	42.0	84.0	Хөрсний өнгөн давхаргаас дээж авч шинжлүүлнэ.	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2.2	Хөрсний хүнд металлын агууламж /Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu, /	Үйлдвэрийн зүүн талд Хаягдлын сангийн урд Хүдрийн овоолго	Хагас жил тутам	1	38.0	152.0		
	Дүн					236.0		
<b>3. Усны чанар</b>								
3.1	Усны ерөнхий химийн шинжилгээ /рН, Ca <sup>2+</sup> , Mg <sup>2+</sup> , Ca <sup>2+</sup> , NH <sub>4</sub> <sup>+</sup> , Na <sup>+</sup> , K <sup>+</sup> , Fe <sup>3+</sup> , SO <sub>4</sub> <sup>2+</sup> , HCO <sub>3</sub> <sup>-</sup> , Cl <sup>-</sup> , NO <sub>2</sub> <sup>-</sup> , NO <sub>3</sub> <sup>-</sup> /	Гүний худаг-1,2 Хаягдлын сан	Улирал тутам	1	100.0	400.0		MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага
3.2	Ундны ус, хаягдал усны бактериологийн шинжилгээ	Гүний худаг-1,2 Хаягдлын сан	Улирал тутам	1	152.0	608.0		
	Дүн					1,008.0		
	<b>Нийт дүн</b>					<b>1,479.00</b>		

#### 4.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төсөв

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар .	Сар .	Сар .		
1	2	3	4	5	6	7	
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажилчдад хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардал	IV	VII	X	Удирдлага	Ажилчдын экологийн боловсролыг дээшлүүлэх, Эрсдэлээс урьдчилан сэргийлэх дадал олгох ХАБЭА-н соёлд хэвшүүлэх зорилготой.
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбарыг уурхайн кэмп, төв хаалга, үйлдвэрийн бүсэд байрлуулах	500.0	II	VI	X	ХАБЭАБО	
<b>Нийт</b>		<b>500.0</b>					

#### 4.10. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 18. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төсөв

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Үйл ажиллагааны зардал	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	Сумын хурлын заал
2	Дорноговь аймгийн Байгаль орчны газар тайлан хүргүүлэх	Хянуулах	БОМТ болон Хяналт шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	500.0	Биелэлтийг хянуулах	Аймгийн байгаль орчны газар
<b>Нийт</b>					<b>500.0</b>		

#### 4.11. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

Хүснэгт 19. Нийт төсвийн задаргаа

№	Төсвийн төрөл	Дүн мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	5562.7
2	Нөхөн сэргээлтийн төсөв	1,800.0
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	8000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төсөв	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсөв	1,500.0
6	Осол, эрсдэлийн менежментийн төсөв	1,000.0
7	Хог, хаягдлын менежментийн төсөв	1,500.0
8	Орчны хяналт шинжилгээ	1,479.0
9	Удирдлага зохион байгуулалт	500.0
10	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	500.0
<b>Нийт зардал</b>		<b>21,842.0</b>